



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦАГААН-ҮҮР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 05 сарын 02 өдөр

Дугаар А/29

Цагаан-Үүр сум

Г Дархлаажуулалтын арга хэмжээг Г
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.5.14, 59 дүгээр зүйлийн 59.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4, 9 дүгээр зүйлийн 9.1, Засгийн газрын 2018 оны 225 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын хэмжээнд мал, амьтны халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээг тухайн өвчний тархвар зүй, голомтын судалгаанд үндэслэн 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдрөөс 11 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд үр дүнтэй зохион байгуулахыг “Арцарам” ХХК-ий захирал (Э.Онон)-д үүрэг болгосугай.

2. Мал сүргийг халдварт, гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээнд голомт бүхий газар нутагт байгаа мал сүргийг бүрэн хамруулсан эсэхэд хяналт тавьж, холбогдох тайлан, мэдээг нэгтгэн ажиллахыг сумын Мал эмнэлгийн тасгийн Мал эмнэлгийн улсын байцаагч (Э.Цэцэнгэрэл)-д үүрэг болгосугай.

3. Дархлаажуулалтын арга хэмжээнд шаардагдах түлш, шатахууны зардлыг сумын Засаг даргын тамгын газрын холбогдох зардлаас зарцуулахыг Санхүүгийн албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Н.Ганчимэг), нягтлан бодогчийн үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ц.Ундармаа) нарт зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (С.Үүрийнбаяр)-д үүрэг болгосугай.

ДАРГА



А.БАТМӨНХ

6704301119